



**ХОЁР ТАЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол Улсын Засгийн газар болон Тайландын Вант Улсын Засгийн газар (цаашид "Талууд" гэх),

Хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг цаашид боломжит бүх салбарт урт хугацаанд хөгжүүлэн, урагшлуулахыг хүсч,

Хамтын ажиллагааны асуудлаар санал бодлоо тогтмол солилцож, зөвлөлдөж, үйл ажиллагаагаа уялдуулж байх зорилгоор хоёр талын механизм байгуулах шаардлагын үүднээс,

Ийм механизм байгуулах нь хоёр талын хамтын ажиллагааны хүрээг өргөсгөж, түвшинг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт бат итгэж,

Хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааг монгол, тай ард түмнүүдийн сайн сайхны төлөө тэгш байдал, харилцан ашигтай байх, бүрэн



эрхт байдлыг бүрэн хүндэтгэх зарчимд үндэслэн хөгжүүлэх, олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг дэмжих сонирхлоо дахин нотолж,

Хоёр орны хооронд үйлчилж буй хэлэлцээрүүдийг харгалзан үзэж,

Дор дурьдсан зүйлийг харилцан тохиролцов:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Талууд улс төр, эдийн засаг, соёл, худалдаа, хөрөнгө оруулалт, бизнес, аж үйлдвэр, шинжлэх ухаан ба технологи, техникийн хамтын ажиллагаа зэрэг төрөл бүрийн салбарт хоёр орны хамтын ажиллагааг бүхий л талаар хөгжүүлэн бэхжүүлэхтэй холбоотой асуудлыг авч хэлэлцэх Хоёр талын хамтын ажиллагааны зөвлөл байгуулна.

2 ДУГААР ЗҮЙЛ

Зөвлөлийн зорилт нь хоёр орны хамтын ажиллагааны тухайн үеийн байдлыг тогтмол үнэлж дүгнэж байх, хамтран ажиллах харилцааг цаашид өргөжүүлэн эрчимжүүлэх арга замыг тодорхойлох, нийтлэг сонирхлын асуудлаар хоёр орны хоорондын ойлголцлыг сайжруулж, илүү ойр зөвлөлдөн, үйл ажиллагаагаа уялдуулахад оршино.

3 ДУГААР ЗҮЙЛ

Зөвлөлийг Монгол Улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тайландын Вант Улсын Гадаад хэргийн яамны Байнгын нарийн бичгийн дарга нар даргалах бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Талууд тогтооно. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Гадаад хэргийн яам болон



холбогдох бусад яам, засгийн газрын байгууллагуудын ахлах албан тушаалтнууд багтана.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Зөвлөл нь өөрийн дүрэм, журмаа тодорхойлж, тусгайлсан асуудлуудаар хороо, дэд хороо эсхүл ажлын хэсгийг зохих тохиолдолд байгуулж болно.

5 ДУГААР ЗҮЙЛ

Зөвлөл нь хоёр жил тутам буюу хоёр Талын тохиролцсон аливаа бусад цагт Монгол эсхүл Тайланд Улсад ээлжлэн хуралдана. Зөвлөлийн хурлын хэлэлцэх хэргийн төслийг тухайн хурлыг хүлээн авагч улс хурал болохоор төлөвлөсөн хугацаанаас наад зах нь хоёр сарын өмнө санал болгох бөгөөд хэлэлцэх хэргийн төслийг Талууд харилцан тохиролцоно.

6 ДУГААР ЗҮЙЛ

Энэхүү санамж бичгийг хэрэгжүүлэх буюу хэрэглэхтэй холбогдуулан үүссэн аливаа маргаан, саналын зөрүүг Талууд яриа хэлэлцээ хийх, зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

7 ДУГААР ЗҮЙЛ

Энэхүү санамж бичиг нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү санамж бичиг нь таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд аль нэг Тал энэхүү санамж бичгийг дуусгавар болгох талаар зургаан сарын өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдээгүй тохиолдолд дараа дараагийн таван жилийн хугацаанд аяндаа сунгагдана.



Энэхүү санамж бичиг дуусгавар болоход үргэлжилж буй хөтөлбөрүүдийн хувьд энэхүү санамж бичгийн заалтууд Талууд өөрөөр тохиролцоогүй бол тухайн хөтөлбөр дуусах хүртэл үйлчилнэ.

8 ДУГААР ЗҮЙЛ

Аль ч Тал энэхүү санамж бичгийн бүх буюу зарим хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хоёр Талын тохиролцсон аливаа нэмэлт, өөрчлөлт нь хоёр Талын тогтоосон өдөр хүчин төгөлдөр болно.

ДЭЭР ДУРЬДСАНЫГ НОТЛОН холбогдох Засгийн газруудаас зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчид энэхүү санамж бичигт доор гарын үсэг зурцаав.

Улаанбаатар хотноо 2013 оны 4 дүгээр сарын 28 -ны өдөр монгол, тай, англи хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Санамж бичгийг тайлбарлахтай холбоотой саналын зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ТАЙЛАНДЫН ВАНТ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

ЛУВСАНВАНДАНГИЙН БОЛД

СУРАПОНГ ТОВИЧАКЧАЙКУЛ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

ЕРӨНХИЙ САЙДЫН ОРЛОГЧ БӨГӨӨД

ГАДААД ХЭРГИЙН САЙД